

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН САЯ САЯЫН БЭЛТЭЙ МЭДЛЭГТЭН БУЮУ ХАЯГДАЛ БОРЛУУЛАГЧ



Нэг ийм хүн хөрөнгийн зах зээлд эргэлдээд байдгийг бид эртээс мэдэх болсон юм. Манай захирал Р. Содхүү хөрөнгийн зах зээл чинь хөрөнгө мөнгө олох ширгэсгүй ундарга юм шүү дээ хэмээн үргэлж ярьдаг тул нэг удаагийн яриандаа хог түүдэг нэгэн эр энэ зах зээлээс сая сая төгрөг босгосныг жишээ болгон дурдсан юм. Нээрээ бусдад үлгэр болуужин гэж бодоод сайхь эртэй уулзаж ярилцаад сэтгүүлдээ нийтлэхсэн гэж хорхой гозолзон уулзах санаатай анаад байлаа.

Тэр бүр тааралдаж өгөхгүй байсаар нэг өдөр нүүр тулж тааралдаад санаагаа хэлтэл асуултаа өгчих, би бичээд ирье гэхэд нь боловсролтой хүн болохыг нь гадарласан юм. Биеэр уулзаж ярилцмаар байна гэвэл, за за гэж уриалгахан дуугараагүй ч, дургүйцэн цааргалсангүй. Эхнэр, хүүхэдтэй эсэхийг нь асуутал доош тонгойн удтал дуугүй суухад нь дэмий ч юм асууж эмзэг сэтгэлийг нь сэдрээчихэв үүдээ гэж санаа зовлоо. Гэвч дуртай сэдвийг нь хөндөн яриад эхлүүт тэр хүн илэн далангүй сайхан яриа өрнүүлснийг сэтгүүлийнхээ уншигчидтай хуваалцахаар шийдлээ.

Биднийг ярилцаж байх зуурт нэг хижээл эр орж ирээд хувьцааны арилжаанд оролцож үзэх гэсэн юм, зөвлөгөө өгөөч гэж хүсээд, хэдэн зүйл лавлаад

гарахад мань А. Чулуун гуай энэ хүн одоо энэ талаар юу ч мэдэхгүй байгаа юм чинь гэндэнэ дээ. Хувьцааны ханшийн хэд хэдэн жилийн судалгаагүй хүн энэ зах зээлд эрсдэлд орох нь амархан байдаг. Өндөр үнэтэй хувьцаа аваад л шатчихдаг гэж харамсах, зөвлөхийн завсар хэдэн үг хавчуулаад авлаа. Цагтаа чадалдаа эрдэж, дарга нартайгаа шөргөөцөлдсөн адармаатай эрийн хуйх явсан бололтой, ярианы явцад энэ байдал мэдэгдэж байв.

Үзэх өнгө гундуу ч гэлээ сийрэгхэн толгойтой эр ажээ. Хог түүж гэдэс тэжээдэг хүмүүсийг дорд үздэг нь бидний гэм биш, зан. Худал хэлж, хулгай хийдэггүй, хүн алж, хүрээ талаагүй ийм номхон борчуудыг бид харин өөдрөг нүдээр харж байгууштай. Бид хаясан хогоо өөрсдөө цэвэрлэдэг бил үү, огт үгүй, харин тэд бидний хаясныг цуглуулж орчин тойрныг цэвэрлээд тушаах газар нь хүргэж арван таван төгрөг олж гэдсээ тэжээж байна, хүний хаягдлаас өөрт хэрэгтэй гэж санагдсанаа өмсөж зүүж, идэж ууж ч байгаа биз. Юу нь буруу байх билээ дээ. Хог хаягдлаар бизнес эрхлэх санааг тэд анх гаргасан байж таарна, тийм хүмүүсийг хог түүгчид гэж доромж үзэхийн оронд хаягдал борлуулагч гэж эерэг нэрийдэх нь зүйд нийцмээр байлаа.

“ХЗЗ”: Таны нэр алдар хэн бэ? Хэдэн настай вэ?, Аль нутаг усны хүн бэ? Ямар ажил төрөл хийж явав даа?

... : Намайг Цагаан Адууч овгийн Аюурын Чулуун гэдэг. Одоо жаран тавтай. 1945 онд Дорнод аймгийн Баян-Уул суманд төрсөн. Хоёрдугаар анги хүртлээ сумандаа сурч байгаад хотод ирж, Төв аймгийн арван жилийн дунд

сургууль төгссөн. Монгол Улсын Их Сургуульд суралцаж, 1970 онд барилгын эдийн засагч мэргэжилтэй болсон. Төв аймгийн барилгын контор, Борнуур сум- Сангийн аж ахуйд барилгын эдийн засагчаар ажиллаж байлаа.

“ХЗЗ”: Ямархуу амьдрал туулсан бэ? Гэр бүл, үр хүүхэдтэй юу?

А.Чулуун: Би огт гэрлээгүй хүн

. Ажил хийгээд л амьдралаа болгоод явдаг байлаа. Шударгаар ажилладаг байлаа. Харин дарга нар намайг огт үзэхгүй. Тэр үед сэхээтэн хүнийг намд авахгүй гэсэн зарчимтай байсан. Заавал л ажилчин, малчин хүнийг намд элсүүлж авдаг байлаа. Намын гишүүн хүн л дээш дэвшдэг. Харин нам бус хүнийг бол дор нь ажлаас нь халчихдаг байсан даа. Намын гишүүнээ намын

байгууллага нь хамгаалдаг. Харин надад тийм хамгаалалт байхгүй байсан болохоор ажлаасаа халагдаж орхисон доо.

Цэдэнбал даргын үед л дээ. Борнуурт ажиллаж байгаад хотод ороод ирсэн. Танил талгүй, тал тохой татахгүй л бол огт ажил олдохгүй юм билээ. Тэгээд яахав дээ намд элсэх санаатай байгаад, Барилгын цэрэгт орж нормын ажил хийсэн. Цэргийн газар намд элсэхэд гайгүй гэж дуулсан юм. Худлаа байсан юм билээ. Тэгээд л 1985 онд ажлаасаа гарсан.

Түүнээс хойш самар түүлээ. Анчдын байнгын баригадтай цуг анд явна. Тарвага өвчиж махыг нь идээд хоёр сар болдог байлаа. Ажлаас буухдаа 1200 төгрөгтэй, хоёр дөчийн бидон махтай л орж ирнэ шүү дээ. Бас тарваганы тос шахаад тушаана. Ингээд 5 жил болж байтал ардчилал гарч ирээд хуучны юм огт хэрэггүй болдог юм байна.

“ХЗЗ”: *Та одоо хаана аж төрж байна даа ? Архи тамхи хэрэглэх үү?*

А.Чулуун: Одоо нэг хашаа байшинд л амьдардаг. Би насаараа архи уусангүй, тамхи хэрэглэсэнгүй.

“ХЗЗ”: *Одоо өдөр тутамд та юу хийдэг вэ?*

А.Чулуун: Яахав дээ, хэдэн төгрөгний тэтгэвэртэй. Өмнө нь ямар хуримтлал гэж юм байсан биш. Зах зээл эхэлсний дараа ундаа зарж эхэлсэн. Ундаа ч эхлээд 1төгрөг 20 мөнгө, жижиг шилтэй нь 80 мөнгөний үнэтэй байлаа. 20 шилийг дэлгүүрээс аваад зах дээр хүрч нэгийг нь 5 төгрөгөөр зардаг байсан. Дараа нь үнэ нь нэмэгдээд, 50 төгрөгөөр аваад 100 төгрөгөөр зардаг боллоо. Хэсэг хугацааны дараа үйлдвэрлэж байгаа хүмүүс нь өөрсдөө зах дээр хүргэж бөөний үнээр зардаг болоод бид зарж чадахаа больсон.

Тэгээд л шил, лааз түүж, хүчит шонхор зах дээр очиж яс авдаг л даа. Харин хувьцааны зах зээлээс

бага саг мөнгө олж эхэлсэн дээ. Би гэхдээ их сайн хийж чадаагүй ээ.

“ХЗЗ”: *Танай хашаан дотор ямар бараа, түүхий эд байгаа вэ?Түүгээрээ өдөрт хэдэн төгрөг олдог вэ?*

А.Чулуун: Шил, лааз гэх зэрэг юм бий. Боргио гээд шил байдаг даа. Тэрийг чинь үйлдвэр дээрээ 40 төгрөгөөр авна. Замын хажуугаар тушаавал 20 төгрөгөөр өгнө. Хуванцар савыг л гэхэд зах дээр килограммыг нь 400 төгрөгөөр авч байхад замын хажууд тушаавал 200 төгрөгөөр л авдаг юм. Өдөрт яахав дээ 1000 төгрөг л олдог юм даа. Бас өвөл болохоор хуванцар сав үнэгүй болчихно. Өвөл хадгалж байгаад хавар зарах гэхчлэн арга хэрэглэнэ дээ.

“ХЗЗ”: *Таныг ажихад боловсролтой хүний байртай юм. Та хөрөнгийн зах зээлийн талаар хэзээнээс мэддэг болов?*

А.Чулуун: 60-аад оны үед Төв хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Д.Төмөр-Очирын орчуулсан Эмиль Золягийн “Мөнгө” гэдэг ном гарсан байдаг юм. Түүнийг уншаад “Энэ ч үнэхээр сайхан юм. Даан ч манайх шиг социалист оронд байхгүй юм даа” гэж бодож байлаа.

Хоёр дахь зах зээл эхлэхэд миний бодож байснаар тэр үед брокерийн компани дээр очоод үзэхээр миний уншсан ном, эдийн засагч байхдаа бөглөж байсан хүснэгт, маягтууд бүгд л байх нь тэр. Гэхдээ манайд хөрөнгийн зах зээл гэдэг цоо шинэ зүйл байсан.

“ХЗЗ”: *Та брокер дилерын аль нүүсээр үйлчлүүлдэг хүн бэ?*

А.Чулуун: Олон пүүсээр орсон. Тэр үед гар дээрээс үнэт цаасыг их зардаг байсан юм. Зах дээр 100 төгрөгөөр зарж байхад нь аваад брокерын пүүсүүд рүү тараадаг. Данс нээлгээ гэхээр надад бичиг баримт байхгүй юм хойно. Худалдаж авсан бичгээ хувьцаа болгох хооронд нөгөө дилер чинь завшчихдаг байлаа. Бараг тэн

хагасыг нь луйвардуулсан даа. “Орчил” гээд брокерын пүүст анх данс нээлгэж байлаа. Тэгээд яахав дээ, жаахан юм олж авсан.

“ХЗЗ”: *Одоо та баримт бичигтэй юу? Өөрийн харилцах дансаар үйлчлүүлдэг биз дээ?*

А.Чулуун: Одоо ч зах зээл жигдэрчихлээ. Бусдын адил өөрийнхөө дансаар л арилжаанд орж байгаа. Одоо сонирхож эхэлж байгаа хүмүүс ашигтай ажиллахад хэцүү л дээ. Дор хаяж гурван жилийн ханшийн хэлбэлзлийг мэдэж байх шаардлагатай болно. Хувьцаа гурван жилийн өмнө ямар үнэтэй байсан. Одоо ямар үнэтэй болсон зэргийг харьцуулж харах хэрэгтэй болдог.

“ХЗЗ”: *Одоо харахад та энэ зах зээлийн жинхэнэ мэргэжилтэн болсон байна. Зах зээлийн мэдрэмжтэй болсон уу?*

А.Чулуун: Одоо жаахан мэдрэмжтэй болжээ. Хувьцааны зах зээл чинь ерөөсөө л мэдрэмж шүү дээ. Саяхан “Хувьцааны зах зээлээс мөнгө хийх арга” шинэ ном худалдаанд гарсан байсан. Их ухаантай хүний бичсэн ном байна билээ. Тэр ном дээр хувьцааны зах зээл мөрийтэй тоглоомтой адилхан гэсэн байсан. Нээрээ л адилхан бооцоо тавьж байгаа биз дээ. Америкт олон мянган компани байгаа байх. Манайд цөөхөн хэдхэн л компани бий. Хямдхан компаниудын хувьцааг авбал өсөх юм байх гэж бодоод олон хувьцаа авсан зарим нь ч түгжигдчихээд л байгаа “Хэрлэн хивс”, “Ачаа тээвэр”, “Их даац”, “Баян Итгэлт” гэхчлэн одоо захаасаа аваад байхгүй болж байна.

“ХЗЗ”: *Хувьцаа цөөн хүний гарт хэт төвлөрснөөс шалтгаалж одоо зарим нэг компани хэлбэрээ өөрчилж байна. Энэ байх ёстой зүйл үү?*

А.Чулуун: Хязгаарлагдмал хариуцлагатай компани байх үндэсгүй л дээ. Огт болохгүй зүйл. Америкт гэхэд хэдэн зуун жилийн

өмнө байгуулагдсан хувьцаат компаниуд өнөөдрийг хүртэл ажиллаж л байх юм. Яагаад гэвэл хувьцаа нь тарчихсан байгаа. Жижиг хувьцаа эзэмшигч гэхэд цөөхөн хэдэн хүн байгаа. Тэд цуглаад л хурлаа хийчихдэг, хувьцаат компани хэвээрээ яваад байдаг. Манайд ч мөн л адил жил бүр хурлаа хийдэг. Хүлээж авдаг олон сайхан компани байна.

“ХЗЗ”: *Та хөрөнгийн зах зээлээс хэдий хэмжээний мөнгө олсон бэ?*

А.Чулуун: Шалихгүй ээ. Хувьцааны ханш өсвөл 60 сая орчим болох болов уу. Одоо зарвал 10 сая л болох байх.

“ХЗЗ”: *Хүмүүс энэ зах зээл рүү ормоор байдаг хэдий ч нэг л учраа олохгүй байх шиг. Тийм үү?*

А.Чулуун: Хүмүүс аажимдаа ойлгоод арилжаанд ордог хүний тоо олширно. Орж эхлээд жилийн дараа гэхэд учраа олох л байх.

“ХЗЗ”: *Уул уурхайн компаниуд хөрөнгийн зах зээл дээр орж ирвэл хэр өөрчлөлт гарах бол?*

А.Чулуун: Төр засгаас ер нь сайн хайхрахгүй байна. Хувьцаат компанийг олшруулах бодлого явуулах хэрэгтэй. Нэг хүн зочид буудал барилаа гэхэд хувьцаа хэлбэрээр хөрөнгө цуглуулахыг шаардах хэрэгтэй. Тухайлбал: “Зүч”, “Кэмпенски” “Чингис” гэх мэт томоохон зочид буудал хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэртэй. Хувьцаат компани байсан бол ард түмэнд ашигтай байх байсан.

“ХЗЗ”: *Цэвэрхнээр хэлэхэд одоо та хаягдал цуглуулдаг юм байна. Өөр ажил төрөл эрхлэх бололцоотой болчихжээ. Та мөнгөө яаж эргэлдүүлж байна? Амьдралаа өөрчилж гэх сонирхол алга уу?*

А.Чулуун: Одоохондоо мөнгө минь тийм их хэмжээнд хүрээгүй л дээ. Хүн ч бас байгаа байдалдаа дасчих юм даа. Одоогийн нөхцөлд 100 сая төгрөгтэй л болохгүй бол

амьдрах арга алга. Байгаа мөнгөөрөө байравчих юм бол юугаа эргүүлэх вэ? Хэсэг хугацааны дараа байрныхаа мөнгийг төлж чадахаа болино шүү дээ. Харин 100 сая төгрөгтэй байгаад 60 саяар нь байр авчих юм бол 40 саяынх нь хүүгээр байрныхаа хөлсийг төлөөд байх бололцоотой. Гадаадын баячуудын түүхээс ч үзэхэд зорилгодоо хүрэхийн тулд хүлээж мөнгөө хуримтлуулдаг. 100 саятай болсныхоо дараа амьдралаа өөрчилж болно шүү дээ.

“ХЗЗ”: *Тэгвэл Та үнэт цаасны арилжаанд оролцоод жилд хэдэн төгрөг олдог вэ?*

А.Чулуун: Сүүлийн хоёр жилд гэхэд л 3 сая төгрөг олж байна даа.

“ХЗЗ”: *Таны эцсийн зорилго юу юм бэ?*

А.Чулуун: Мөнгөө л өсгөх зорилго байна.

“ХЗЗ”: *Таны ойр байгаа хүмүүс дотроос хувьцааны зах зээлд ордог хүмүүс бий юу?*

А.Чулуун: Бараг байхгүй дээ.

“ХЗЗ”: *Та үнэт цаасны зах зээл хүмүүст хэрэгтэй гэж хэлдэггүй юм уу? Эсвэл тэд ойлгодоггүй юм уу?*

А.Чулуун: Хэлэх шаардлага алга, өөрсдөө л мэднэ үү гэхээс биш би хэлээд дэмий юм билээ. Хүн чинь эрдмээ хүнд бас зүгээр өгдөггүй шүү дээ. Цаанаасаа ч энийг дэлгэрүүлэхгүй гэсэн бодлого байсан байж болох. Үнэт цаастай холбоотой юм нууц байлаа л даа. Хэдэн хувийг нь авбал эзэн нь болох вэ? гэдэг ч хаалттай л байлаа. Жишээлбэл: “Монгол шилтгээн” компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоход ажилчид нь хуралд ерөөсөө ордоггүй. Яагаад гэвэл тэдний дарга нь ажилчдадаа нууцаа хэлэх хүсэлгүй байгаа болохоор тэр.

“ХЗЗ”: *Та олж авсан мэдлэг, мэргэжил, хөрөнгийн зах зээлээс авсан туршлагаараа л хоолоо олж*



идэж байгаа хүн байна шүү дээ?

А.Чулуун: Тийм л юм даа, нээрээ ч

“ХЗЗ”: Та ном их унших уу?

А.Чулуун: Уншина. Миний зорилго л юм чинь бизнесийн чиглэлийн бүхий л номыг мөнгө хайрлахгүй л авч харна. “Баян аав, Ядуу аав”, “Санхүүгийн эрх чөлөөнд хүрэх зам”, Артим Тарасовын “Саятан” гээд бүх л номыг үзэж байна. Мөн “Дэлхийн суут жанжнууд” гэх мэт суут хүмүүсийн номыг их уншина. Хамгийн сүүлд “Хувьцааны зах зээлээс мөнгө хийх арга” гэсэн ном уншсан. Саяхан “Сталин” гээд ном гарч гэнэ. Тэрийг авч уншина даа.

“ХЗЗ”: Номоо Та хэзээ уншдаг вэ? Өглөө хэдэн цагт босдог вэ?

А.Чулуун: Нас ахиад өглөө эрт босдог болж дээ. Өглөөгүүр яваад түлээ түлш түүдэг. 8 цаг болгож гэртээ ирээд л номоо уншиж эхэлнэ. Сонин бас их уншина аа. Зах дээгүүр “Маш нууц”, “Ноцтой мэдээ” сонинг хямдруулж зардаг. Тэрнийг бас алгасалгүй авч уншдаг.

“ХЗЗ”: Ном олонтой юу? Хэдий хэр ном бий вэ?

А.Чулуун: Ном олон бий. Нэг уншсан номоо хэд хэд уншина. “Бизнесийн 100 хууль” гэх мэт номыг дахин дахин уншина шүү.

“ХЗЗ”: Та гадаад хэлтэй юу?

А.Чулуун: Яахав дээ. Дотоодын дээд сургууль төгссөн хүн орос хэлийг ямар хэмжээнд мэддэг билээ. Тэр л хэмжээнд мэднэ. Англи хэлийг харин үзээгүй ээ.

“ХЗЗ”: Та үнэт цаасыг сонгохдоо ямар арга хэрэглэж байна. Тусдаа нууц арга байна уу?

А.Чулуун: Нууц арга гэх юм юу байх вэ. Бирж дээр би өдөр болгон л очиж арилжааны мэдээ авдаг юм. Тэрийгээ хадгалаад л байдаг. Өнгөрсөн жил ямар үнэтэй байсан билээ? гээд эргүүлээд харна л даа. Цээжинд ч бас орчихсон байдаг. Өнгөрсөн жил гэдэн төгрөг байсан. Одоо ийм байна. Цаашдаа

ингэх болов уу гэж бодож байж л наймаа хийнэ шүү дээ. Харин одоо хувьцаанууд цөөрчихөөр хэцүү юм.

“ХЗЗ”: Засгийн газрын бодлого хөрөнгийн зах зээлд нөлөөлж байгаа болов уу?

А.Чулуун: Манай ард түмний олонх нь хувьцаа гэдэг зүйлийн талаар огт мэдэхгүй байгаа. Тэдний амьдралд ч нөлөө үзүүлэхгүй байна.

“ХЗЗ”: Тэгвэл мэдүүлэхийн тулд яах ёстой вэ?

А.Чулуун: Мэдүүлээд байх шаардлага байхгүй. Аяндаа л мэднэ үү гэхээс биш. Хичээнгүй нэг нь ном, сониноос уншаад мэдлэгээ нэмэгдүүлж болох юм. Надтай цуг эдийн засгийн сургууль төгссөн хүн хүртэл энэ зах зээлийн талаар огт ойлгодоггүй юм.

“ХЗЗ”: Та ханшийн мэдээг харж байгаа д л захиалгаа өгчихдөг үү? Өдөр болгон л брокерын компаниар үйлчлүүлэх үү?

А.Чулуун: Хөрөнгийн биржээс мэдээгээ авчихна. Тэгээд мөнгө хуримтлуулж байгаад л дансандаа хийгээд арилжаанд оролцоно. Хэдийд ямар хувьцаа авах вэ? гэдэг их чухал. Мөнгөө дансанд хийгээд хүлээж л байсан нь дээр юм билээ. Тэгээд хямдарсан үед нь авна. Нэгэнт авсан хувьцаагаа үнэ өсөхийг хүлээнэ.

“ХЗЗ”: Хямралт байдал Танд хэрхэн нөлөөлсөн бэ? Та алдагдалд орсон уу?

А.Чулуун: Хямрал бидэнд мэдэгдээгүй. Явдгаараа яваад л байсан. Би хөдөө аж ахуйн яамны хажууд байдаг “Алтан хоромсог” пүүсээр үйлчлүүлдэг юм. Хааяа л очдог. Одоо компаниудын хурлын материал авахаар долоо хоног бүр очиж байгаа. Дансандаа мөнгө хийж чадахгүй болохоор тэр болгон захиалга өгөөд байхгүй л дээ. Хэрэгтэй хувьцаа авч байж л өгөөж нь гарна.

“ХЗЗ”: Та хувь нийлүүлэгчдийн хуралд идэвхтэй суудаг уу? Тэр хурал ямар учиртай юм бэ?

А.Чулуун: Хувь нийлүүлэгчдийн хуралд сууснаар нэлээд мэдээлэл авна. Энэ компанийн эзэд, тэдгээрийн яриа хөөрөө гээд олон юм хардаг. Бас хурлын материал дээр их олон юм бий. Зарим нь ч бизнесийнхээ нууцыг хамаагүй дэлгэчихсэн л байдаг. Энэ ер нь хэр зэрэг компани вэ? гэдэг нь аяндаа л мэдэгддэг. Хувьцаа эзэмшигчдийн хуралд очсоор байгаад дарга нар нь таньдаг болчихсон. Дахиад очиход урд нь ирж хуралд сууж байсан хүн байна гээд сүрхий л юм болно. Зарим хурал дээр үг хэлэхээр хүмүүс их гайхдаг.

“ХЗЗ”: Банканд мөнгө хадгалуулах, хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах хоёрын аль нь илүү найдвартай вэ?

А.Чулуун: Хувьцаа худалдаж авсан нь хавигүй дээр шүү дээ. Хөрөнгийн зах зээлд зөв хөрөнгө оруулалт хийвэл хоёр жилд гурав дахин өсч байхад банкинд хугацаатай хадгалуулахад дөрвөн жилд нэг дахин өснө. Хугацаагүй бол бүүр бага .

“ХЗЗ”: Аль нь илүү эрсдэлтэй вэ?

А.Чулуун: Төр банкны хадгаламжийг даана гэсэн болохоор гайгүй л байна. Гэхдээ мөнгөө өсгөх найдвартай арга хөрөнгийн зах зээл дээр л байна даа.

“ХЗЗ”: Хөрөнгийн зах зээл дээр ямар зүйлийг хийчихээсэй гэж Та боддог вэ?

А.Чулуун: Хувьцаат компаниудаа олшруулах хэрэгтэй байна. Хувьцаат компани болгоод хөрөнгө босгож болох зүйлийг луйвардаад авчихаад байх юм. Дарханы сликат, шохойн үйлдвэр гэж байсан. Цэдэнбал даргын үед л баригдсан үйлдвэр шүү дээ. Гэнэтхэн л хязгаарлагдмал хариуцлагатай компани болчихсон л байх юм. Ямар замаар хувьд оччихов оо.

Менежментийн хувьчлал гэж бас нэг луйвардах арга байна. Бөхийн өргөөг анх барихад улсаас 800 сая төгрөг гаргаад л барьж байлаа. Энэ

...Аливаа зүйлд эрч инерцээ алдвал өнгөрдөг гэдэг...

мөнгийг улсаас гаргалгүй хувьцаа гаргаад иргэдээс татаж болох байсан шүү дээ. Худалдаа үйлдвэрийн дээд сургууль гэхэд менежментийн хувьчлалаар хүнд зүгээр өгч байна. Гэтэл яагаад хувьцаа гаргаж зарж болдоггүй юм бэ? Энэ мэтчилэнгээр дэмжихгүй байхаар хувьцаат компани бий болж, хувьцаат нийгэм хөгжихгүй байна.

Зах зээл дээр найдвартай хувьцаат компаниуд бий болох тусам иргэд хувьцааг нь ихээр авна. Улмаар ашгаа хүртээд амьдрал нь сайжирна шүү дээ. Ерөнхий сайд С.Батболд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлнэ гэж ярьж эхэлсэн. Хөгжүүлбэл хэрэгтэй л байна.

Хөрөнгийн зах зээл сүйрэхэд бэлэн байна. Зарим хувьцаат компани хязгаарлагдмал хариуцлагатай компани болоод, зарим эзэд нь хувьцаат компанийнхаа хөрөнгө, мөнгийг идэж, уугаад худлаа дампууруулж байна. Үүнийг хуулиа хэрэгжүүлдэг ерөнхийлөгч огт хайхрахгүй байна. ХК-ийн тоо өдөр ирэх тусам цөөрч байна. Бирж дээр хэдхэн компанийн хувьцаа арилжигдаж, илэрхий луйвар, дээрэм явагдаж байна. ХХК болно гэдэг бол дээрэм. Бирж дээр хамгийн том дээрмийг Улсын Их Хурал хийсэн. Өөрийн харьяа байгууллага болох Үнэт цаасны хороо, Одоогийн Санхүүгийн зохицуулах хороогоор дамжуулан Дарханы цемент ХК-ийн хувьцааг 77 төгрөгөөр үнэлж Эрэлийн Б.Эрдэнэбатад дээрэмдэн авч өгсөн. Ер нь компани хувьцаа эзэмшигчдийнхээ хурлыг хийгээд том хувьцаа эзэмшигчид нь ХХК болох шийдвэр гаргадаг. Тэгээд жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцаанд үнэ тогтоогоод авчихдаг. Энэ нь үндсэн хуульд заасан хувийн өмчийг дайчлан авах юм уу, хурааж авч болохгүй гэсэн заалтыг

зөрчиж байгаа юм. Одоо “АПУ” ХК-ийн хувьцаа /1 хувьцаагаа 100 болгон жижиглэсэн/ 200 000 төгрөг, “Тавантолгой” ХК-ийн хувьцаа 195 000 мянган төгрөг хүрч байна. Тэгвэл улсад дээгүүр орох “Цемент ХК” –ийн хувьцааг 77 төгрөгөөр хүчээр авна гэдэг ямар том дээрэм болох нь тодорхой. Улс орон даяар “Цемент” ХК-ийн хувьцаатай хүмүүс олон байгаа. Бүгдийг дээрэмдсэн. Хэдэн хүний хичнээн хувьцааг дээрэмдсэн нь нууц байгаа. Би л гэхэд 849 хувьцаагаа дээрэмдүүлсэн. Мөн ийм дээрмийг “Улсын Их Дэлгүүр”, “Эрдэнэт хивс” ХК хийх гэж завдсаар байна.

Мөн Санхүүгийн зохицуулах хороо өмнөх өдрийн арилжаанаас хувьцааны үнийг 15 хувиас дээш, доош захиалга өгч болохгүй гээд шийдвэр гаргасан нь чөлөөт худалдааг хязгаарласан хэрэг. Хүн өөрийнхөө юмыг хэдээр үнэлэх нь тэр хүний хэрэг баймаар юм. Мөн “Анод”, “Зоос” банкны хувьцаа эзэмшигчид маш их хохирч байна. “Термэс центр”, “Оллоо” зэрэг хувьцаат компанийн хувьцааны доод хязгаарыг 75 төгрөгөөр тогтоосон байгаа нь зөвхөн үнийг хязгаарлаад зогсохгүй чөлөөт сэтгэлгээг хүртэл боймлож байгаа хэрэг. Магадгүй зарим хүн сонирхолгүй хувьцаа авчихжээ гээд 50 төгрөгөөр зараад үнэ нь өсөх магадлалтай хувьцаа аваад алдагдлаа нөхнө гэсэн тооцоо хийж болох юм.

“ХЗЗ”: *Анхны мэдэгдэхүүнгүй хүн оролцоход хэцүү биз?*

А.Чулуун: Зах зээлийнхээ байдлыг мэдэхгүй байгаа болохоор үнэтэй үед нь авах зэргээр эрсдэлд их орно л доо. Ханшийн циклийнх нь үнэтэй үед нь авчихбал шагна л гэсэн үг шүү дээ.

Хувьцааг үнэ нь өсөх гэж байгаа үед нь мэдэрч авах ёстой. Анх орж

байгаа хүнд бол ийм мэдрэмж төрөхгүй л дээ.

“ХЗЗ”: *Анх орж байгаа хүмүүс хаанаас мэдээлэл авах вэ? Мэдээлэл олж авах боломж хэр зэрэг байна вэ?*

А.Чулуун: Энэ бол хувь хүнээс өөрөөс нь хамаарна. Ном сонин уншдаг хүн бол олоод үзчихэж болно. Олж уншихгүй бол юугаа мэдэх вэ. Зарим нь ч хичнээн тайлбарлаад ч огт ойлгодоггүй хүн байдаг шүү.

“ХЗЗ”: *Ямар салбарт хувьцаа гаргавал ирээдүйтэй вэ? Шинээр ямар хувьцаа гараад ирвэл худалдаад авчих юмсан гэж боддог вэ?*

А.Чулуун: Туршлага дээрээ үндэслээд үзэхэд зочид буудлын салбарын хувьцаанууд нэлээд сайн өсөх юм. Уул уурхайн салбарын хувьцаа ч мөн дажгүй байх юм аа. Уул уурхай гэхэд хувьцаагаар барилга байгууламж, тоног төхөөрөмж гэх мэт зөвхөн тэр ордын дээр байгаа зүйлсийг л хувьчилсан байж таарна. Газар доорхи баялгийг нь хувьчлаагүй шүү дээ. Тэр хувьцаат компанийг хувьцааны төвлөрлөөр хэн нэгэнд дангаар нь өгчихнө гэдэг улсад их л алдагдалтай баймаар юм.

“ХЗЗ”: *Одоо та ямар зорилго тавьж байна вэ?*

А.Чулуун: Зорилго гэх ч юу байхав дээ. Нас 65 хүрчихлээ. Бизнес гэдэг чинь инерцээрээ явдаг гээд байгаа. Эрч инерцээ алдвал өнгөрдөг гэдэг. Тухайлбал: Би онц сурдаг байлаа. Эцэг, эх маань нэг жил сургуулиас завсардуулсан. Хойтон жил нь эргээд сургуульдаа ороход багш нар солигдсон, өөр ангид ороод миний нөгөө онц сурч байсан нэр төр алга болчихсон байж билээ. Бүх л зүйлийг шинээр эхлэх болж байгаа юм. Энэ хооронд инерцээ алдсан л юм билээ дээ.

Ярилцсан: Б.Мөнгөнсүх